

ЗАСАГ ДАРГА

БАТЛАВ

Х.ХҮРЭЛЧУЛУУН

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт: I Сэлэнгэ үүлдэр
II КЦТолгойн үүлдэр
III Герефорд

2. Стандарт:

Нийлүүлэх бараа нь дор дурьдсан техникийн тодорхойлолт, стандартанд нийцсэн байна.

№	Барааны нэр	Техникийн тодорхойлолт
1	Сэлэнгэ, үүлдрийн үхэр	Үхэр нь Хүрэн халзан, Улаан зүстэй мухар, түргэн өсөлттэй, лагс биетэй, өргөн гүн цээжтэй, чац богиной, толгой хөнгөн хүзүү өргөн, богино, булчин их сайн хөгжсөн, хонгоны булчин борвио хүртэл унжсан, нимгэн, зөөлөн үсээр бүрхэгдсэн сийрэг арьстай, тэгш зөв гишгэлттэй, туруу нь бат бөх, бие нь ерөнхийдөө бөөрөнхийвтөр, сэрвээ, нуруу, ууц, хондлой өргөн, тэгш шулуун, булчин мах биеийн хэсгүүдэд жигд сайн хөгжсөн, гуя хонго махлагдуу, чийрэг бие цогцостой
2	КЦТолгойт үүлдрийн үхэр	Үхэр махлаг хэв шинжтэй духаараа өргөн, толгой нь дунд зэрэг, гүн өргөн цээжтэй, омруу шалан сайн хөгжсөн, сул зузаан арьстай, богиновтор шилбэтэй, тэгш зөв гишгэлттэй, туруу нь бат бөх, бие нь ерөнхийдөө бөөрөнхийвтөр, сэрвээ, нуруу, ууц, хондлой өргөн, тэгш шулуун, булчин мах биеийн хэсгүүдэд жигд сайн хөгжсөн, гуя хонго махлагдуу, чийрэг бие цогцостой.

Жич: Стандартын шаардлага хангасан өндөр ашиг шимт бүгд 12 сараас дээш настай 7 толгой бухыг нийлүүлнэ.

- Нийлүүлэх бух нь ялган тэмдэглэх хувийн дугаартай, удмын санд бүртгэгдсэн, удам зүйн гэрчилгээтэй байна.
- Тухайн аж ахуйд 3 жил анаплазмоз, бабеозиз, тейлероз өвчин, сүүлийн 1 жилийн хугацаанд шүлхий, боом өвчин гараагүй байх
- Нийлүүлэх үхэр тус бүрд сүүлийн 6 сарын хугацаанд хийсэн вакцины нэр төрөл, вакцин үйлдвэрлэгчийн нэр хаяг зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлсэн байх.